



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам”-ыг нэгдүгээр, “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлт”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг байгууллагынхаа төсөвт тогтмол тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Цогтбаатар), Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т тус тус даалгасугай.



САЙД

Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

11200106

## ТУШААЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн салбарт бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдээр хариуцлагатай жижүүр томилж, амралтын өдрүүдийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажилладаг.

Энэ асуудлыг баяр, амралтын тухай бүр тушаал гаргаж шийдвэрлэж ирсэн нь салбарын тусламж, үйлчилгээний бэлэн байдлын талаар мэдээ гаргах, мэдээлэлд нэгдсэн дүгнэлт гаргаж ажиллахад зарим талаар хүндрэлтэй асуудлууд тулгарч ирсэн.

Иймд, салбарт асуудлыг нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааг тогтворжуулах, байнгын болгох зорилгоор “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалаар батлагдсан бүртгэл, тайлангийн маягтыг шинэчлэх хүрээнд маягтыг шинээр боловсруулж, төсөлд тусгасан.

Энэхүү тушаалаар хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагаа, эрх үүрэг, ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдал болон мэдээ авах, нэгтгэх асуудлыг журамлахаар орууллаа.

Энэ тушаал гарснаар бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдээр эрүүл мэндийн салбарын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах нөхцөл бүрдэнэ.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ГАЗАР

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 01 сарын 24 ны өдрийн  
А/Б дугаар тушаалын хавсралт

БҮХ НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯР, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙН АМРАЛТЫН ҮЕД  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг зүйл.**

1. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй, бэлэн байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
2. Бүх шатны эрүүл мэндийн байгууллага энэхүү нийтлэг журмыг үндэслэн, байгууллагын өвөрмөц нөхцөл байдалтай уялдуулан тусламж, үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавих хариуцлагатай жижүүрийг томилсожуулан, үйл ажиллагааны удирдамжийг батална.
3. Удирдамжид бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлт, учирч болзошгүй эрсдлийг тооцох, сэргийлэх, үйлчлүүлэгчид чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьж ажиллах чиглэлээр хариуцлагатай жижүүрийн үүрэг, хариуцлагыг тусгана.
4. Удирдамжид тухайн байгууллагын болон харьяа байгууллагынхаа тоног, төхөөрөмж, техникийн бэлэн байдал хангуулах, ус, цахилгаан, калаалт, хийн хангамж, хүчилтөрөгч, түүний хангамж, эмнэлгийн тонсг төхөөрөмж, түргэн тусламжийн автомашины бэлэн байдалд хяналт тавьж ажиллах аргачлал, үйл ажиллагааг тусгана.
5. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед Эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын **“Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягт”**-д заасан маягтын дагуу холбогдох эрүүл мэндийн байгууллагууд гаргаж мэдээлнэ.

**Хоёр. Удирдлага, зохион байгуулалт.**

1. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед Эрүүл мэндийн яамнаас улс орны хэмжээний нийгмийн эрүүл мэндийн үйл явдлууд болон

салбарын нийтлэг үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах жишиг чиг үүрэг бүхий ерөнхий жижүүрийг томилно.

2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлт"-ийг гаргуулан, хүлээн авч, нэгтгэх, мэдээлэх жишиг чиг үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилно.
3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт тухайн орон нутгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн үйл явдал, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулж ажиллах жишиг чиг үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилно.
4. Эрүүл мэндийн байгууллагууд байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагаа, тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний бэлэн байдал болон харьяаллын хүн амын эрүүл мэндэд хяналт тавих жишиг чиг үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилно.
5. Хариуцлагатай жижүүрүүдийн үйл ажиллагаа нь 24 цагийн тасралтгүй байдлыг хангасан байх бөгөөд, энэхүү тушаалаар баталсан нийтлэг удирдамжийн хүрээнд үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байна.
6. Ерөнхий жижүүрээс бусад хариуцлагатай жижүүр нь энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлт"-ийг үнэн зөв гаргаж, баталгаажуулан холбогдох шатанд ирүүлж байх нийтлэг үүрэгтэй.

#### **Гурав. Мэдээний урсгал.**

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт ажиллаж буй хариуцлагатай жижүүр нь харьяа байгууллагаас мэдээг авч, нэгдсэн дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн хариуцлагатай жижүүрт ирүүлнэ.
2. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгүүд мэдээг ЭМХТ-ийн хариуцлагатай жижүүрт ирүүлнэ.
3. ЭМХТ байгууллагуудаас мэдээг бүрэн гаргуулан авч салбарын нэгдсэн дүн мэдээг гаргаж Эрүүл мэндийн яаманд ирүүлнэ.

4. ЭМХТ-ийн хариуцлагатай жижүүр нь тайван үед 24 цагийн байдалаар, эрсдэлт нөхцөл байдал, НЭМ-ийн ноцтой байдал үүссэн үед Эрүүл мэндийн яамны ерөнхий жижүүр, удирдлагуудтай зөвшилцөн, мэдээ авах цагийг шинэчлэн тогтоож, мэдээг дараах өдрийн өглөөний 09 цагт баггаан ЭМЯ-ны ерөнхий жижүүрт ирүүлнэ.
5. Эрүүл мэндийн яамны ерөнхий жижүүр нь ЭМХТ-өөс нэггэн ирүүлсэн мэдээнд дүгнэлт хийж, холбогдох удирдлага, байгууллагыг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.
6. Эрүүл мэндийн яамны 24 цагийн турш мэдээ хүлээж авах утасны дугаар: 11-323002, ЭМХТ-ийн хариуцлагатай жижүүрийн утас-70128801 байна.

***Дөрөв. Эрүүл мэндийн яамны ерөнхий жижүүрийн нийтлэг үйл ажиллагаа.***

1. Эрүүл мэндийн яамны холбогдох газар, хэлтсийн дарга, Төрийн ариун бичгийн дарга, Дэд сайд, Сайдыг мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд шаардлагатай шийдвэрлүүлэх асуудлыг тухайн хяналт тавьж ажиллах газар, хэлтсийн дарга нарт танилцуулж, хамтарч шийдвэр гаргаж ажиллана.
2. Ажлын зайлшгүй шаардлагаар асуудал хариуцсан мэргэжилтнийг дуудах, аппаратыг бүрэн бүрэлдэхүүнээр яаралтай цуглуулах шаардлагатай гэж үзвэл, удирдлагад танилцуулан шийдвэр авч, шуурхай зохион байгуулна.
3. Мэдээ өгч байгаа эрүүл мэндийн байгууллагын хариуцлагатай жижүүрүүдийн үйл ажиллагаа, цаг баримталж байгаа байдалд хяналт тавьна.
4. ЭМХТ-өөс ирүүлсэн мэдээ, иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч, жижүүрийн бичмэл тайланд тэмдэглэн, шаардлагатай тохиолдолд тухайн өдөр хяналт тавих газар, хэлтсийн даргад мэдээлж, асуудлыг хамтран шийдвэрлэх арга хэмжээний зохицуулалтыг хийж ажиллана.
5. Эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн үед шаардлагатай мэдээ авах цагуудыг шинэчлэн тогтоож, ЭМХТ, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн тухай бүр нэгтгүүлж, дүгнэлт хийж ажиллана.
6. Нийгмийн болон тусламж, үйлчилгээний эрсдэлт хүчин зүйлийг тооцоолох, хяналт тавих, эх, хүүхдийн эндэгдэл, олныг хамарсан осол гэмтэл, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал гарсан тохиолдолд мэдээлэл, харилцаа холбоо, удирдлага, зохион байгуулалтаар шуурхай хангаж ажиллах арга хэмжээг авна.

7. Эмнэлгийн тусдамж, үйлчилгээний асуудлаар үүссэн эрсдэлт хүчин зүйлийг нэн түрүүнд Эмнэлгийн тусламжийн газрын даргад мэдээлж, авах арга хэмжээний чиглэл авч, авсан арга хэмжээг бичмэл тайланд тусгана.
8. Салбарын мэдээг ЭМХТ-өөс хүлээн авч, үйл явцын бичмэл тайлан, мэдээний товч дүгнэлтийг бичнэ.
9. Хуваарийн хамгийн сүүлийн өдөр гарах хариуцлагатай жижүүр амралтын өдрүүдийн нийт хугацааны мэдээний нэгтгэлийг гаргаж Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулж, хүлээлгэн өгнө.

**Тав. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хариуцлагатай жижүүрийн нийтлэг чиг үүрэг.**

1. Салбарын мэдээг мэдээг холбогдох байгууллагуудаас бүрэн гүйцэтгэж авч нэгтгэнэ.
2. Мэдээ ирүүлээгүй буюу цагтаа мэдээ ирүүлээгүй байгууллагын удирдлагатай холбогдож асуудлыг тодруулж, шалтгааныг тайланд тусгаж, нөхөж авч мэдээнд нэгтгэнэ.
3. Эрүүл мэндийн байгууллагуудын хариуцлагатай жижүүрийн цаг барилт, жижүүрийн үүргийг тасалдуулсан байдал, мэдээ дутуу авах болон дутуу өгөх, жижүүрийн хугацааны мэдээг албажуулан нэгтгэл хийхгүй буух, хариуцлагатай жижүүрийн үүрэг, үйл ажиллагаанд тусгасан асуудлыг шалтгаангүй зөрчсөн асуудалд хяналт тавьж ажиллана.
4. Хуваарийн хамгийн сүүлийн өдөр гарах хариуцлагатай жижүүр нэгдсэн тайлан бичиж, мэдээг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулж, Төрийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

**Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагатай жижүүрийн нийтлэг чиг үүрэг.**

1. Эрүүл мэндийн байгууллага нь хариуцлагатай жижүүрийн нэрс, тогтмол нээлттэй байх утасны дугаар, байх цахим хаягийг, ЭМЯ, ЭМХТ-д урьдчилан ирүүлсэн байна.
2. Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан мэдээг гаргасан ЭМХТ-ийн хариуцлагатай жижүүрт ирүүлж, шаардлагатай тохиолдолд утсаар тодруулга өгч ажиллана.

3. Хариуцлагатай жижүүр нь тухайн өдрийн хуваарьт цагтаа ирж, жижүүрийн хавтас дахь материал, өмнөх жижүүрийн нэгтгэсэн мэдээ, тайлангай танилцана.
4. Жижүүр хүлээж авсан тухайгаа тухайн өдөр хяналт тавьж ажиллах удирдах ажилтанд мэдэгдэнэ.
5. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагатай жижүүр нь ирүүлж байгаа мэдээний үнэн зөвийг хариуцаж ажиллах ба тухайн ирүүлж буй мэдээг байгууллагын удирдлагаас тухайн өдөр хяналт тавьж ажиллаж байгаа албан тушаалтанд хянуулж, баталгаажуулж ирүүлнэ.
6. Нийтийг хамарсан ноцтой байдал үүссэн үед шалтгаан, нөхцөл байдал, үүсч болзошгүй эрсдлийг тооцож холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
7. Гамшиг осол, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тухай бүрт шаардлагатай нэмэлт мэдээлэл, үйл ажиллагааны явцын тайлан холбогдох байгууллагаар гаргуулан бүх шатны удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана.
8. Шаардлагатай үед мэдээллийг Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шуурхай удирдлагын төв /хэлтэс/-д шууд мэдээлж, тайланд тусгаж ажиллана.

#### **Долоо. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг.**

1. Бүх нийтийн амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, байгууллагын техник, тоног, төхөөрөмжийн бэлэн байдал, хийн хангамж, эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдал, түргэн тусламжийн машин, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах төлөвлөлт, зохицуулалтыг хийж ажиллана.
2. Бүх нийтийн амралтын үед эх, хүүхдийн эрүүл мэнд, төрөлт, нас баралт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хордлого, халдварт өвчин, гэнэтийн осол гэмтэл, яаралтай, түргэн тусламж, цаг агаарын аюулт үзэгдэл, олныг хамарсан өвчлөл, эндэгдэлд хяналт тавьж, мэдээлж ажиллана.
3. Байгууллагын хариуцлагатай жижүүрийн үүрэгт дээрхи асуудлуудад хяналт тавих чиг үүргийг тодорхой тусгаж өгнө.
4. Бүх нийтийн баяр, тэмдэглэлт өдрөөс 14 хоногийн өмнө тухайн өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр хийх албан тушаалтныг томилж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

5. Хариуцлагатай жижүүрт зориулж холбогдох журам, заавар, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын болон бусад байгууллагын утас, цахим хаяг, бусад мэдээ, мэдээллийг багтаасан жижүүрийн хавтас /цомог/-ыг бэлтгэнэ.
6. Хариуцлагатай жижүүрээр ажиллах мэргэжилтэн болон бүх албан тушаалтнуудад урьдчилсан мэдээллийг өгч, чиг үүргийг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулна.
7. Хариуцлагатай жижүүр ажиллах өрөөнд интернет холболт бүхий компьютер, хэвлэгч, 24 цаг нээлттэй байх суурин утас байрлуулна.
8. Хариуцлагатай жижүүрийг амралтын өдрүүдэд гэрээс нь авах, гэрт нь хүргэх унаа, тээврийн хэрэгслээр хангах болон ажиллах нөхцөл, цай хоолны асуудлыг нь байгууллага өөрийн нөхцөл байдалд тохируулан шийдвэрлэнэ.